# НИЙСЛЭЛИЙН
# ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 10 өдөр Дугаар А/152 Улаанбаатар хот

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын
балансаас хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 267,787,500 (хоёр зуун жаран долоон сая долоон зуун наян долоон мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ (А.Одбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ (Ү.Оюунзул)-т үүрэг болгосугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ (А.Одбаяр), “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ (Ү.Оюунзул)-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА М.БАЯРАА

1119282496 ☏:2576589

11505000477

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 10-ны А/152 дугаар тушаалын хавсралт

1118282498 2675589

## Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага : Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглал-танд орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Машин, тоног төхөөрөмж | | | | | | | | | | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ |
| 1 | Эко автобус /цахилгаан/ | J-800EV | 2015 | ш | 10 | 26,778,750 | 267,787,500 | 252,910,416.67 | 14,877,083.33 | |
| Машин, тоног төхөөрөмжийн дүн | | | | | | | 267,787,500 | 252,910,416.67 | 14,877,083.33 | |
| Нийт хөрөнгийн дүн | | | | | | | 267,787,500 | 252,910,416.67 | 14,877,083.33 | |